

**БАТЛАВ: “ДЦС-4” ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ**

Ү.ТӨМӨРХУЯГ

Огноо: 2020 оны 05 дугаар сарын 13

**ЭМ ЭМНЭЛЭГИЙН МАТЕРИАЛ НИЙЛҮҮЛЭХ
ҮНИЙН САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ**

Харьцуулалт/ гэрээний **ДЦС4/2020-249**
дугаар:

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**

1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**

2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.

2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**

3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:

 - (а) Үнийн санал;
 - (б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) ТООЗ-д заасан шаардлагууд
- 4. Тогтмол үнэ**

4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**

5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.

5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
- 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**

6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**

7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.

7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь нэг багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.

Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**

8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<p>Сүүлийн нэг жилийн санхүүгийн баталгаажсан тайлан</p> <ul style="list-style-type: none"> • Санхүүгийн тайлан 2019 он, • компанийн гэрчилгээний хуулбар, • эм, эмнэлэгийн бараа материал нийлүүлэх тусгай зөвшөөрлийн хуулбар, туршлагын мэдээлэл, ирүүлнэ. • НӨАТ-ийн гэрчилгээ • Татварт өргүй гэсэн цахим татварын тодорхойлолт
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: <i>“ДЦС-4” ТӨХК Худалдан авах ажиллагааны хэлтэс Улаанбаатар хот Баянгол дүүрэг 20-р хороо Эрчим хүчний гудамж</i></p> <p>Давхар болон өрөөний дугаар: <i>Захиргааны байр 3-р давхар 310 тоот өрөө мэргэжилтэн Ж.Айдос Утас: 70181309</i></p> <p>Огноо: <i>2020 оны 05-р сарын 20 -ны өдөр</i> Цаг: <i>10 цаг 00 минут</i></p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер нээх хаяг, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: <i>“ДЦС-4” ТӨХК Худалдан авах ажиллагааны хэлтэс Улаанбаатар хот Баянгол дүүрэг 20-р хороо Эрчим хүчний гудамж</i></p> <p>Давхар болон өрөөний дугаар: <i>Захиргааны байр 3-р давхар 310 тоот өрөө</i></p> <p>Огноо: <i>2020 оны 05-р сарын 20-ны өдөр</i> Цаг: <i>10 цаг 30 минут</i></p>
ТӨӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: ДЦС4/2020-249 дугаартай Эм эмнэлэгийн материал нийлүүлэх нэг багцаас бүрдэнэ</p>

БАРААНЫ ЖАГСААЛТ БА ТОДОРХОЙЛОЛТ

Эм, эмнэлэгийн материал

Дд	Барааны нэр	Тоо хэмжээ	Х.Нэгж	Техникийн тодорхойлолт
1	Адреналин	10	ампул	ОХУ -ын эмийн бүтээгдэхүүн, хайрцгандаа 10 ампул, 1 мл
2	Актовегин 40мг-5мл	250	ампул	Австри улсын "Такеда" эмийн бүтээгдэхүүн, 40 мг, 5 мл, хайрцгандаа 5 ампул.аар савлагдсан.
3	Алое 1мл	365	ампул	ОХУ -ын эмийн бүтээгдэхүүн, хайрцгандаа 10 ампул, 1 мл.ээр савлагдсан.
4	Аминазин	10	ампул	ОХУ -ын эмийн бүтээгдэхүүн, хайрцгандаа 10 ампул, 1 мл.ээр савлагдсан.
5	Анальгин 50%-2мл	20	ампул	ОХУ -ын эмийн бүтээгдэхүүн, хайрцгандаа 10 ампул, 2 мл.ээр савлагдсан.
7	Апаурин 10мг2мл тарилгын уусмал	45	ампул	ОХУ -ын эмийн бүтээгдэхүүн, хайрцгандаа 10 ампул, 2 мл.ээр савлагдсан.
8	Аскорбины хүчил 5% 2мл	650	ампул	"Нахиа" эмийн үйлдвэрийн бүтээгдэхүүн, хайрцгандаа 10 ампул, 2 мл.ээр савлагдсан.
9	Аспирин 100 мг	100	Таблетка	"Монос" эмийн үйлдвэрийн бүтээгдэхүүн, хайрцгандаа 100 таблетка, 100 мг
10	Атенолола	400	Таблетка	ХБНГУлсын"Денкфарма"-ийн бүтээгдэхүүн, 25 мг, хайрцгандаа 100 таблетка
11	Атропин сульфат	10	ампул	ОХУ -ын эмийн бүтээгдэхүүн, хайрцгандаа 10 ампул, 1 мл
12	Багаж ариутгах ариун уусмал	10	л	"Монхимо" эмийн үйлдвэрийн бүтээгдэхүүн, 1 флакондоо 2000 мл.ээр савлагдсан.
13	Банк сордог	2	ширхэг	БНСАУлсын "Hansol medical" эмийн үйлдвэрийн бүтээгдэхүүн, 30 ширхэгтэй.
14	Бидоп	30	Таблетка	Унгар Улсын "Gedeon Richter"-ийн бүтээгдэхүүн, 10 мг
15	Бинт	1000	ширхэг	"50-н Ус" эмийн үйлдвэрийн бүтээгдэхүүн, хайрцгандаа 25 ширхэг.
16	Валидол	120	Таблетка	ОХУ -ын эмийн бүтээгдэхүүн
17	Валокордин	10	Фл	ХБНГУлсын "Krewel Meuselbach GmbH"-ийн бүтээгдэхүүн, 20 мл
18	Витамин РР	400	ампул	ОХУ -ын эмийн бүтээгдэхүүн, хайрцгандаа 10 ампул, 1 мл.ээр савлагдсан.
19	Глюкоза	10	Фл	ОХУ -ын эмийн бүтээгдэхүүн, хайрцгандаа 10 ампул, 10 мл.ээр савлагдсан.
20	Глюконат кальци	40	ампул	ОХУ -ын эмийн бүтээгдэхүүн, хайрцгандаа 10 ампул, 10 мл.ээр савлагдсан.
21	Гордокс 100000 ед-10,0мл	10	ампул	Унгар Улсын "Gedeon Richter"-ийн бүтээгдэхүүн, 100000Ед, 10 мл
22	Гутлын өмсгөл	2000	ширхэг	Монгол Улсын "Мөнхийн тун" эмийн үйлдвэрийн бүтээгдэхүүн, өмсгөл томтой, нэг удаагийн, бат бөх материалтай байх.
23	Даралт хэмжигч аппарат /зөөврийн/	7	ком	БНХАУлсын "Yuwell" эмийн үйлдвэрийн бүтээгдэхүүн.
24	Дексаметазон	75	ампул	Чех Улсын "KRKA"-ийн эмийн бүтээгдэхүүн, хайрцгандаа 25 ампул, 1 мл
25	Дексаметазонтой нүдний дусаалга	10	Фл	ОХУ -ын эмийн бүтээгдэхүүн, хайрцгандаа 1 фл, 5 мл.ээр савлагдсан.
26	Дибазол 1%-5мл	20	ампул	ОХУ -ын эмийн бүтээгдэхүүн, хайрцгандаа 10 ампул, 5 мл.ээр савлагдсан.
27	Дигоксин	10	ампул	ОХУ -ын эмийн бүтээгдэхүүн, хайрцгандаа 10 ампул, 1 мл.ээр савлагдсан.
28	Диклоденк 100мг	600	Таблетка	ХБНГУлсын"Денкфарма"-ийн бүтээгдэхүүн, 100 мг, хайрцгандаа 100 таблетка
29	Диклоденк 75мг-3мл	100	ампул	ХБНГУлсын"Денкфарма"-ийн бүтээгдэхүүн, 75 мг, 3 мл, хайрцгандаа 10 ампул
30	Димедрол	103	ширхэг	ОХУ -ын эмийн бүтээгдэхүүн, хайрцгандаа 10 ампул, 1 мл.ээр савлагдсан.

31	Диротон 5мг	30	Таблетка	Унгар Улсын "Gedeon Richter"-ийн бүтээгдэхүүн, 5 мг
32	Дицинон 2,0 мл	15	ампул	"Лес" эмийн үйлдвэрийн бүтээгдэхүүн, 250 мг, 2 мл
33	Дуслын систем	650	ширхэг	"Монос" эмийн үйлдвэрийн бүтээгдэхүүн, уутандаа 25 ширхэг, эрвээхэй хар зүүтэй.
34	Зажем шулуун 18см	20	ширхэг	БНХАУ-ын бүтээгдэхүүн, зэвэрдэггүй ган материалтай.
35	Ибупрофен денк	1000	Таблетка	ХБНГУ-ын "Денкфарма"-ийн бүтээгдэхүүн, 400 мг, хайрцгандаа 100 таблетка
36	Иод 5мл	100	Фл	"Монхимо" эмийн үйлдвэрийн бүтээгдэхүүн, 1 флакондоо 5 мл.ээр савлагдсан.
37	Кавинтон 10мг-2.0	100	ампул	Унгар Улсын "Gedeon Richter"-ийн бүтээгдэхүүн, 10 мг, 2 мл
38	Калий смесь 100мл	60	Фл	Монгол Улсын "IVICO" эмийн үйлдвэрийн, 100 мл
39	Кальци хлорид 10%-10мл	10	ампул	ОХУ -ын эмийн бүтээгдэхүүн, хайрцгандаа 10 ампул, 10 мл.ээр савлагдсан.
40	Каптоприл (денк)	800	ширхэг	ХБНГУ-ын "Денкфарма"-ийн бүтээгдэхүүн, 25 мг, хайрцгандаа 100 таблетка
41	Кардиовит	30	ампул	ОХУ -ын эмийн бүтээгдэхүүн, хайрцгандаа 3 ампул, 3 мл
42	Кокарнит 0.5%-2мл	30	ампул	ОХУ -ын эмийн бүтээгдэхүүн, хайрцгандаа 3 ампул, 2 мл
43	Кокорбоксилаза	200	ампул	ОХУ -ын эмийн бүтээгдэхүүн, хайрцгандаа 10 ампул, 2 мл, 50 мг
44	Кордиамин	10	ампул	ОХУ -ын эмийн бүтээгдэхүүн, хайрцгандаа 10 ампул, 1 мл.ээр савлагдсан.
45	Лабор 250мл	11	Фл	Монгол Улсын "IVICO" эмийн үйлдвэрийн, 250 мл
46	Лориста 25мг	560	Таблетка	Чех Улсын "KRKA"-ийн эмийн бүтээгдэхүүн, хайрцгандаа 28 таблетка, 25 мг
47	Магни сульфат	30	ампул	ОХУ -ын эмийн бүтээгдэхүүн, хайрцгандаа 10 ампул, 10 мл.ээр савлагдсан.
48	Мазь вешневский	30	Фл	ОХУ -ын эмийн бүтээгдэхүүн, хайрцгандаа 30 гр.аар савлагдсан
49	Малгай (Нэг удаагийн)	800	ширхэг	БНХАУ -ын эмнэлгийн бүтээгдэхүүн, хайрцгандаа 50 ширхэгээр савлагдсан.
50	Маск (Нэг удаагийн)	709	ширхэг	БНХАУ -ын эмнэлгийн бүтээгдэхүүн, хайрцгандаа 50 ширхэгээр савлагдсан, 3 давхар шүүлтүүртэй, резинэн оосортой.
51	Мебо шархны тосон түрхлэг 40 гр	20	Фл	БНХАУ -ын "Мебо" эмийн бүтээгдэхүүн, хайрцгандаа 40 гр.аар савлагдсан.
52	Мэс заслын хутганы ир	100	ширхэг	БНХАУ -ын эмнэлгийн бүтээгдэхүүн, хайрцгандаа 100 ширхэгээр савлагдсан, хэмжээ тотмой байх.
53	Мэс заслын хутганы иш	8	ширхэг	БНХАУ -ын эмнэлгийн бүтээгдэхүүн, хэмжээ тотмой байх.
54	Наалт 3х6см	600	ширхэг	БНХАУ -ын эмийн бүтээгдэхүүн, хайрцгандаа 50 ширхэгээр савлагдсан.
55	Наалт 5х8см	400	ширхэг	БНХАУ -ын эмийн бүтээгдэхүүн, хайрцгандаа 50 ширхэгээр савлагдсан.
56	НАКО	50	Фл	Тайвань Улсын эмийн бүтээгдэхүүн, 500 мл савлагдсан
57	Натри салицилат	20	ампул	Монгол Улсын "Цомбо" эмийн үйлдвэрийн бүтээгдэхүүн, хайрцгандаа 10 ампул, 10 мл
58	Натри хлорид 0.9%-100мл	450	ампул	Монгол Улсын "IVICO" эмийн үйлдвэрийн, 100 мл
59	Натри хлорид 0.9%-2 мл	650	ампул	Монгол Улсын "IVICO" эмийн үйлдвэрийн, 2 мл, хайрцгандаа 50 ампул
60	Натри хлорид 0.9%-200мл	250	Фл	Монгол Улсын "IVICO" эмийн үйлдвэрийн, 200 мл
61	Нейрорубин 3 мл	200	ампул	Швейцарь Улсын "Merha" эмийн үйлдвэрийн бүтээгдэхүүн, хайрцгандаа 5 ампул, 3 мл
62	Нитроглицерин	40	Таблетка	ОХУ -ын эмийн бүтээгдэхүүн, 0.001 мг
63	Нифедипин денк 10мг	300	ширхэг	ХБНГУ-ын "Денкфарма"-ийн бүтээгдэхүүн, 10 мг, хайрцгандаа 100 таблетка
64	Нифедипин денк 20мг	300	Таблетка	ХБНГУ-ын "Денкфарма"-ийн бүтээгдэхүүн, 20 мг, хайрцгандаа 100 таблетка
65	Новокайн	100	ампул	Монгол Улсын "IVICO" эмийн үйлдвэрийн, 2 мл, хайрцгандаа 50 ампул
66	Нормодипин 10мг	30	Таблетка	Унгар Улсын "Gedeon Richter"-ийн бүтээгдэхүүн, 10 мг

67	Ношпа 40мг	100	Таблетка	Франц Улсын "Sanofi" эмийн үйлдвэрийн бүтээгдэхүүн, хайрцгандаа 100 таблетка, 40 мг
68	Ношпа 40мг-2мл	25	ампул	Франц Улсын "Sanofi" эмийн үйлдвэрийн бүтээгдэхүүн, хайрцгандаа 25 ампул, 20 мг
69	Нэг удаагийн зүү 23 G	400	ширхэг	БНСАУ-ын эмийн бүтээгдэхүүн, хайрцгандаа 100 ширхэг, 23G
70	Өвдөгний хамгаалалт урт	136	ширхэг	
71	Өвчин намдаах наалт	50	ширхэг	БНСАУ-ын эмийн бүтээгдэхүүн, хайрцгандаа 5 ширхэгээр савлагдсан.
72	Өвчин намдаах хөлдөөгч	15	ширхэг	БНСАУ-ын эмийн бүтээгдэхүүн, 200 мл.ээр савлагдсан.
73	Панангин	20	ампул	Унгар Улсын "Gedeon Richter"-ийн бүтээгдэхүүн, 10 мг, 10 мл
74	Пантоген	35	Фл	Тайвань Улсын эмийн бүтээгдэхүүн, 500 мл савлагдсан дусал тариа.
75	Перкись водород	100	Фл	"Монхимо" эмийн үйлдвэрийн бүтээгдэхүүн, 1 флакондоо 25 мл.ээр савлагдсан.
76	Пластырь 5x500 см	120	ширхэг	ОХУ -ын эмийн бүтээгдэхүүн, хайрцгандаа 1 ширхэгээр савлагдсан, даавуун, наалдах чадвар сайтай байх.
77	Пластырь цаасан	40	ширхэг	БНХАУ -ын эмийн бүтээгдэхүүн, хайрцгандаа 24 ширхэгээр савлагдсан.
78	Преднизолон	10	ампул	ОХУ -ын эмийн бүтээгдэхүүн, хайрцгандаа 10 ампул, 1 мл
79	Прозерин	10	ампул	ОХУ -ын эмийн бүтээгдэхүүн, хайрцгандаа 10 ампул, 1 мл
80	Пульс хэмжигч	4	ширхэг	БНХАУ улсын "Yuwell" эмийн үйлдвэрийн бүтээгдэхүүн.
81	Ревалгин 500мг	500	Таблетка	ОХУ -ын эмийн бүтээгдэхүүн, хайрцгандаа 20 таблетка, 500 мг
82	Реополиглюкин 200мл	15	Фл	Монгол Улсын "IVICO" эмийн үйлдвэрийн, 250 мл
83	Рингер 200мл	174	Фл	Монгол Улсын "IVICO" эмийн үйлдвэрийн, 250 мл
84	Сальброн шахмал	50	Таблетка	4 мг.аар савлагдсан.
85	Санитол 70%-1000.0	22	Фл	"Монхимо" эмийн үйлдвэрийн бүтээгдэхүүн, 1 флакондоо 1000 мл.ээр савлагдсан.
86	Санитол 70%-30.0	5	Фл	"Монхимо" эмийн үйлдвэрийн бүтээгдэхүүн, 1 флакондоо 30 мл.ээр савлагдсан.
89	Спирт денатурант	15	л	"Монос" эмийн үйлдвэрийн бүтээгдэхүүн.
90	Стронжер	50	ампул	БНСАУ-ын эмийн бүтээгдэхүүн, хайрцгандаа 50 ампул, 20 мл
91	Сульфацил натри 20%-5мл	30	Фл	ОХУ -ын эмийн бүтээгдэхүүн, хайрцгандаа 1 фл, 5 мл
92	Тамедин	24	Фл	"Монхимо" эмийн үйлдвэрийн бүтээгдэхүүн, 1 флакондоо 300 мл.ээр савлагдсан.
93	Тариур 10гр	800	ширхэг	БНСАУ-ын эмийн бүтээгдэхүүн, хайрцгандаа 100 ширхэг, 10 гр
94	Тариур 1гр	50	ширхэг	БНСАУ-ын эмийн бүтээгдэхүүн, хайрцгандаа 50 ширхэг, 1 гр
95	Тариур 20гр	100	ширхэг	БНСАУ-ын эмийн бүтээгдэхүүн, хайрцгандаа 100 ширхэг, 20 гр
96	Тариур 3гр	800	ширхэг	БНСАУ-ын эмийн бүтээгдэхүүн, хайрцгандаа 100 ширхэг, 3 гр
97	Тариур 5гр	2000	ширхэг	БНСАУ-ын эмийн бүтээгдэхүүн, хайрцгандаа 100 ширхэг, 5 гр
98	Трамадол	10	ампул	Чех Улсын "KRKA"-ийн эмийн бүтээгдэхүүн, хайрцгандаа 5 ампул, 100 мг
99	Уян боолт	200	ширхэг	БНХАУ -ын эмийн бүтээгдэхүүн, уутандаа 12 ширхэгээр савлагдсан,9*10 см
100	Үзлэгийн бээлий	5500	ширхэг	"Бүрэн хайрхан" эмийн үйлдвэрийн бүтээгдэхүүн, хайрцгандаа 100 ширхэг, М размер, тальгүй
101	Үзлэгийн орны бүтээлэг	55	м	Угаахад агшдаггүй, цайвар цэнхэр өнгөтэй, индүүдлэг сайн авдаг, будаг гардаггүй.
102	Фуросемид	20	ширхэг	ОХУ -ын эмийн бүтээгдэхүүн, хайрцгандаа 10 ампул, 2 мл.ээр савлагдсан.
103	Хиймэл нулимс	16	ширхэг	Энэтхэг Улсын эмийн бүтээгдэхүүн, тосон суурьтай, хайрцгандаа 1 фл, 5 мл
104	Химодин	12	Фл	"Монхимо" эмийн үйлдвэрийн бүтээгдэхүүн, 1 флакондоо 300 мл.ээр савлагдсан.

105	Хөвөн	403	ширхэг	"50-н Ус" эмийн үйлдвэрийн бүтээгдэхүүн, хайрцгандаа 200 ширхэг, 50гр
106	Хурууны лент	2000	Хайрцаг	БНСАУ-ын эмийн бүтээгдэхүүн, хайрцгандаа 50 ширхэгээр савлагдсан.
107	Хэл дарагч	100	ширхэг	БНХАУ -ын эмнэлгийн бүтээгдэхүүн, хайрцгандаа 100 ширхэгээр савлагдсан, модон материалтай байх.
108	Церуглан	120	ампул	Чех Улсын "KRKA"-ийн эмийн бүтээгдэхүүн, хайрцгандаа 5 ампул, 2 мл.ээр савлагдсан.
109	Цитрамон	1200	ширхэг	"Монос" эмийн үйлдвэрийн бүтээгдэхүүн, хайрцгандаа 100 таблетка, 500 мг
110	Чих цэвэрлэгч	1100	ширхэг	БНХАУ -ын эмийн бүтээгдэхүүн, хайрцгандаа 24 ширхэгээр савлагдсан.
111	Щётка	4	ширхэг	
112	Экватор	30	Таблетка	Унгар Улсын "Gedeon Richter"-ийн бүтээгдэхүүн, 10 мг
114	эмийн иж бүрдэл цүнх /авто машин/	4	ширхэг	
115	Энап 1,25 мг	14	ампул	Чех Улсын "KRKA"-ийн эмийн бүтээгдэхүүн, хайрцгандаа 5 ампул, 1 мл
116	Энап 10мг	1000	ширхэг	Чех Улсын "KRKA"-ийн эмийн бүтээгдэхүүн, хайрцгандаа 20 таблетка, 10 мг
117	Энап 5мг	1000	ширхэг	Чех Улсын "KRKA"-ийн эмийн бүтээгдэхүүн, хайрцгандаа 20 таблетка, 5 мг
118	Энап Н	450	ширхэг	Чех Улсын "KRKA"-ийн эмийн бүтээгдэхүүн, хайрцгандаа 20 таблетка, 10 мг
119	Эссенциале	30	ампул	ХБНГУлсын "Наттерманн энд Сие Гмбх" эмийн үйлдвэрийн бүтээгдэхүүн, хайрцгандаа 5 ампул, 5 мл
120	Эуфиллин	30	ширхэг	ОХУ -ын эмийн бүтээгдэхүүн, хайрцгандаа 10 ампул, 10 мл.ээр савлагдсан.
121	Яак 40% -10 мл	2	ампул	ОХУ -ын эмийн бүтээгдэхүүн, 100 мл
122	Сахарын тест	100	ширхэг	care sence БНСАУлсын эмийн бүтээгдэхүүн
123	Сахарын үзлэгийн зүү	100	ширхэг	care sence БНСАУлсын эмийн бүтээгдэхүүн

Жич:Барааг нэг доор авах ба захиалгын дагуу 7 хоногийн дотор нийлүүлнэ.

1. БАРААН ДЭЭР НИЙТ ҮНИЙН САНАЛ ИРҮҮЛНЭ.
2. Баглаа, боодол: Зориулалтын дагуу савалж гадуур нь хайрцагласан байна.
3. Бараа хүргэх газар: "ДЦС-4" -ийн төв агуулахад нийлүүлэгч өөрийн зориулалтын машинаар хүргэнэ
4. Үнийн дүнд НӨАТ ТӨЛӨГЧ БОЛ шингээсэн байх.
5. Бараа нийлүүлэлтийн хуваарь ирүүлэх бараа тус бүр дээр.

Дөрөв. Эм эмнэлэгийн материал хээрэгсэл нийлүүлэх үнийн саналын маягт

[огноо]

“ДЦС-4” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал Ү.ТӨМӨРХУЯГ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу захиалгаар нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|--|---|
| 1. Шалгах болон турших | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат хугацаа [нэг] жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.Зах зээлийн үнэ огцом өөрчлөгдсөн тохиолдолд өрсөлдөгч компаниудын үнийн харьцуулалтыг үндэс болгоно |
| 7. Төлбөр | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш 30-аас 90 хоногийн дотор хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй -гээс гэрээг цуцлах | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Захиалагч

Нийлүүлэгч

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1)
 - 1.1. Захиалагч чанарын баталгааны бичиг, худалдан борлуулах зөвшөөрлийг шалгана.
 - 1.2. Нийлүүлэх барааны сав, баглаа боодол нь баталгаажсан эсэхийг шалгана

2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)
 - 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх баримт бичгүүд:
 - 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь, зарлагын баримт;
 - 2) барааны гарал үүслийн гэрчилгээ.1 жилийн хугацаанд саадгүй нийлүүлнэ.

3. Баталгаат засвар (ГЕН-5)
 - 5.1. Нийлүүлэгч нь тээвэрлэлтийн болон ашиглалтын явцад баглаа боодол гэмтсэн, чанар өнгө үзэмж алдагдсан тохиолдолд 100 хувь сольж нийлүүлэх ба үүнээс гарах зардлыг нийлүүлэгч бүрэн хариуцна.

4. Төлбөр (ГЕН – 7)
 - 7.1. Нийлүүлэгчид **Урьдчилгаа төлбөр** олгохгүй бөгөөд гэрээгээр нийлүүлсэн барааны төлбөрийн нэхэмжлэх зарлагын баримт, холбогдох баримтуудыг үндэслэн захиалагч бараа хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төлбөрийг хийнэ.

5. Алданги оногдуулах (ГЕН - 9)¹

Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн барааны үнийн дүнд хэтэрсэн гүйцэтгээгүй үүргийн дүнгийн хоног дутамд **0,1%-ийн алданги ноогдуулна.**

Захиалагч нийлүүлэгчийн төлбөрийг хугацаа хоцроосон тохиолдолд гүйцэтгээгүй үүргийн дүнгийн хэтэрсэн хоног дутамд **0,1%-ийн алданги ноогдуулна.**

Алдангийн нийт дүн гүйцэтгээгүй үүргийн дүнгийн **30%-аас** хэтрэхгүй байна.

Захиалагч

Нийлүүлэгч

¹ Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

БАТЛАВ.

ДЦС-4 ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ

ХХК-ИЙН

ЗАХИРАЛ

Ү.ТӨМӨРХУЯГ

ЗАХИРАЛ

ЭМ ЭМНЭЛЭГИЙН МАТЕРИАЛ ХЭЭРЭГСЭЛ

Дугаар №

Улаанбаатар хот

Нэг талаас **“ДЦС-4” ТӨХК** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **ХХК** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2020 оны ____ сарын ____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч **ДЦС4/2020-249** дугаартай Анхны тусламжийн эмнэлгийн хээрэгсэл -г (цаашид “бараа” гэх) (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрч 1 жилийн хугацаатай гэрээг байгуулав.. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь барааг захиалагчийн захиалгын дагуу 7 хоногийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:
 - Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
 - Үнийн санал;
 - Гэрээний тусгай нөхцөл;
 - Гэрээний ерөнхий нөхцөл;
 - Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ: “ДЦС-4” ТӨХК-ИЙН

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

НИЙГМИЙН АЖИЛ ЭРХЭЛСЭН ДЭД ЗАХИРАЛ:

“.....” ХХК-ИЙН

Н. МӨНГӨН

МЕНЕЖЕР

ЭЗХ-ИЙН ДАРГА

Ж. ОТГОН

САХ-ИЙН ДАРГА:

Д.ТӨМӨРТОГОО

ХААХ-ИЙН ДАРГА:

О.ГАНТӨМӨР

:

ХУУЛИЙН ЗӨВЛӨХ

Ч. БЯМБАСҮРЭН

ГЭРЭЭНИЙ МЭРГЭЖИЛТЭН

С.ДОНИД

